



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/507

Мөрөн сум

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд намрын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 10 дугаар сарын 15-ний өдрийг хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Намрын “Бүх нийтээр мод тарих”-ийн хүрээнд иргэдэд мод тарих соёлыг сурталчлах, айл өрх бүрийг 10 мод тарих, албан байгууллага бүрийг өөрийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод тарихад уриалж, мод тарих газрыг урьдчилан бэлдэх, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тарьсан модны хамгаалалт, цэнэг усалгааг шийдвэрлэж мод тарих ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу Ойн мэргэжлийн байгууллагын өөрийн хөрөнгөөр хийх ойжуулалтын ажлыг хариуцсан сумдын хүрээнд төвлөрүүлсэн байдлаар хийлгүүлэх арга хэмжээ авах, Мөрөн сумын хуваарилсан багуудад тус бүр 500 мод, хариуцсан сум бүрт 1000-аас доошгүй модны суулгацыг нийлүүлж тарьж, ургуулах ажлыг сумдын Засаг дарга нартай хамтран зохион байгуулж ажиллахыг Сум дундын ойн ангийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Аймгийн хэмжээнд таригдсан модыг бүртгэж, хувийн хэрэг хөтлөх ажлыг зохион байгуулах, Мөрөн сумын нийтийн эзэмшлийн ойн зурвас, ногоон байгууламжид 300 ширхэг модны суулгац нийлүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлсн гүйцэтгэгч (П.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011122